

МОНГОЛ ОРНЫ ХУТАГТ ХУВИЛГААДЫН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭН ӨГҮҮЛЭХ НЬ (РАЗМЫШЛЕНИЯ О ХУБИЛГАНАХ МОНГОЛИИ)

М.С. Улзий

В статье автор рассматривает историю проникновения и развития буддизма в Монголии, проводит параллели отличий тибетского и монгольского буддизма. Автор дает распространенное определение термину «хутагт».

Ключевые слова: *Хутагт хувилгад, Монголия, религия, буддизм, происхождение.*

In the article the author considers the history of penetration and development of Buddhism in Mongolia and draws parallels of differences in the Tibetan and the Mongolian Buddhism. The author gives widespread definition of the term “khutagt”. “Khutagt” is a religious title granted to reincarnate lamas in recognition of their spiritual qualities. “Khubilgaan” is the Mongolian translation of the Tibetan term “sprul sku” and signifies the reincarnate manifestation “per se”.

Keywords: *Khutagt Khubilgaan, Mongolia, religion, Buddhism, development.*

Монгол орон дахь хутагт хувилгаадын үүсэл хөгжилийн тойм

Монголын нийгэмд хутагт хувилгаан гэх тусгай нэрийдэл эртнээс буй болохгүй нь мэдээж юм. Эртний монголчуудын ухамсар, танил таавурын хэр хэм дорой буурай бүхэнд үзэл бодол, ухаа санаагийнх эзэмдэн жолоодож, зүүд зэргэлээд нь тайлбар өгч, сүнс сүлдийнхэн сахиул болж, гай барчидыг арилган, чөтгөр шулмаст нь халх дарлаг болх ба цаашилвал тэнгэр газар уул усныхан эзэд сахиулсантай ямар нэгэн зам мөрөөр харьцаа холбоо гаргаж, санаа оноогоо хувилгаж чаддаг байсан тэрхүү онцгой үүрэг тушаалтаныг бөө удган хэмээн бөөрөнхийлөн нэрлэдэг байсныг бид мэднэ. Тэрхүү гартаа тал хэнгэрэг атгаж, биедээ нь гэгээн толь зааж, амнаасаа амьтанд мэдэгдэхгүй ая гаргасан, тэнгэр газар, эзэд сахиулсан хийгээд хүн төрөлхтөний хооронд хэл ул зулгуулдаг галзуу согтуу шинжтэй хүмүүс чухам хэзээгээс бий болсон нь тодорхойгүй боловч билиг ухаан, биелэл хөдөлгөөн үргэлжилүүлсээр байсан бөө удганы тухай тэмдэглэл «Монголын нууц товчоон» жишээ түүнээс нэлээд сүүлийн үеийн сурвалж бичгүүдэд бүр гарч байсан юм. Зүүднээ тайлбарлаж Тэмүүжин Бөртэ Үжинтэй ураг холбосон Дай Сэчэн, заарины төрхийг шинжиж Тэмүүжин улсын эзэн болохыг зөгнэсэн Хорчи Хүйтэний хатгалдаанд эд хэрэглэсэн Буйраг хан, Худуг хоёр, Байрны Усун өвгөнийг бэх өргөмжилөөд цагаан дээл өмсгөж, цагаан морь унуулж дээр суудалд суулгаж он сар үзүүлэх болгосон, мөнх тэнгэрийн зарлиг, хан заарины өгүүллийг мэддэг Хөхэчү гэв тэнгэр хирээ мэдэхгүй аашилж ам алдсан, Өгөөдэй хан өвчлөн ам хэл алдран алжаахад бөө бөөлүүлж төлөг төлөгдүүлэн, Тулуйг золиосонд гаргасан (272) гэхчилэн дурдагдах зүйлст ямар нэгэн бодит бөө удганы бараа сүүдэр буюу аль эсхүл тэдний зан үйлийн онцгой ийм тэмдэг тодрон байгаа нь илэрхий.

«Монголын нууц товчоо»-ны үе хүртлэх бөө удган нь ерийн хүмүүсээс зөн совин, үйл чадавхи

хэмээх хоёр талаар онцгойг байсан шинжтэй. Тэд нар байгаль орчны хувьсал хийгээд шидсэн хүний биед тохиох янз бүрийн хувьслыг ямар нэгэн хэмжээнд урьдчилан бэлгэддэг ой совин, байгаль орчны гай барчид, гамшиг, зудаас шалтгалаж хүн амьтанд нөлөөлсөн өвчин зовлон, үхэл сүйдлийг ямар нэгэн хэмжээнд ангаан домнож, алгасхин тайвшируулж чаддаг чадвараараа тухайн нийгэмийн хүмүүст өргөн хүндлэгдэж байсан нь өргөмжлөн тахигдах хэмжээнд хүрсэн байжээ. Хамаг Монголын язгуур шүтлэгийн чухал нэгэн гишүүн болсон төдийгүй хамаг шүтээний тахил тавиглалын аливан зан үйлийг эзэгнэн гүйцэтгэх үүрэг хариуцлага, тусгай тушаалтан болсон бөө удганууд, хожим нь бурхан шашны соёлын ширүүн дайралтад учирснаар итгэл хүндийг алдаж байр суур нь булаагдах хувь тавиланд зайлшгүй тулгарчээ. Түмэд Алтан хаан төвдийн Содномжамцтай Хөхнуурын Чавчиалд болсон уулзалт дээр тунхагласан төр шашныг тэтгэн хөгжүүлэх цаазын бичигт бөө удганыг гадуурхан үйл ажиллагааг нь хязгаарлаж, бурхан шашныг эрхэмлэн тахиж лам хуврагыг хүндэтгэн дээдлэх чиглэлтэй дурдлага нуудыг гаргасан байжээ. Түүний тухай «Эрдэний товчоо»-нд «тэдний бүгд хамгийг мэдэгч. Алтан хаан хоёр эхлэн. Түйд эхэл, хад, харлигууд, хотлоор зөвшөөн, урьд Монголын улс хүн үхвээс, чинээ чинээгээрээ тэмээ мориог алж, Хойлог хэмээн хамт булах бөлөө. Өдгөө түүнийг тэтчиж чинээ чинээгээрээ, номын зүгт зоригтугай» гэж тэмдэглэсэн байхад, «Алтан хааны тууж»-д «гайхамшигт номын Алтан хаан эхлэн хотол бүгдээрээ сүсэг бишрэлийг үүсгэж бүрин, гадаад онгод цэлигүүдийн эндүүрсэнийг түймэрдээд, гань мунхаг бөө удганыг дуруйдуулын устгаж, гавиат дээд номын төрийг хив зангиа мэт болгож» хэмээн тэмдэглэсэн зүйлс буй.

Эхний тэмдэглэлд үхэж өнгөрсөн хүний хойдох оршуулга тавилганы ажиллагаанд олон тооны амь хороож байсан хэрцгий балмад үйлс хориглогдож, хойдох тэмдэглэлд монголчуудын уламжлалт

шүтлэг онгод цэлэг, бөө удган цаажлагдах болоод, харьцангуйгаар боловсон, энэрэнгүй бурхан номын ёсоор орлогджээ. Түүнээс хойш Монгол оронд гэрээс гаран бурхан номын мөрийг хөөж тангууд Төвдэд очоод сахил санваар авч лам хуврага болоод, бурхан бодисадвыг шүтэн, лам хуврагыг дагаж, ном сударт хийж, сонсон бясалгах эрдэмээр хэдийдэгсэд, Монгол орондоо буцаж ирээд бурхан шашныг дэлгэрүүлэх ажиллагаанд насан турш зүтгэгсэд цолгорон гарчээ. Тэдний дотроос Өвөр монгол оронд ирсэн Найжи тойн, Дөрвөн ойрдод очсон Зая бандид, Халх оронд хүрсэн Жавзандамба нарын бурхан шашин дэлгэрүүлэх үйл ажиллагаанд харшилж байсан монголын хуучин зөрчил бөө мөргөл, онгод тахилга адил бус хэмжээгээр цохилт олсон байна.

Түүгээр зогсохгүй, бурхан шашны номлолд идэвхийлэн орсон монголын ноёд дээдэс хийгээд шашны зүтгэлтэдийн оролцоотой шийдвэрлэн тогтоосон «Ойрд цааз», «Халх журам» мэтийн хууль цаазын бичигт бурхан шашныг төрийн шашинаар дээдэлж, тэдний ашиг тусыг харж хамгаалахаар тунхаглахын хамт бөө удганы үйл ажиллагаа бүрмөсөн чандлан хориглосон байна. Монголчуудын язгуур шүтлэгийн байр суурь, сүр хүч ингэж шахагдан суларч, явах замгүй балран сүйрч бүхийд шинээр мандсан шашин яваандаа нь монгол хүмүүсийн оюун ухааныг хүчтэй эзэмдэн, сүр сүлд, сүнс сахиусынхан өмөг түшиг болж эхэлжээ.

Төвд уламжилалт бурхан шашны зохион байгуулалд хамрагдсан лам хуваргын эгнээнд «хутагт» хэмээх нэгэн тусгай нэрийдэл бий. Тэр нэрийдэл бурхан шашин Энэтхэг оронд эхлэн дэлгэрхэд байгаагүй бөгөөд тэндээс Төвд оронд уламжилсан эхний үед ч байгаагүй юм. «Хутагт» гэдэг үг төвд монголын бурхан шашны ухаанд, сүм хийдэд орон, энгийн лам хуврагаас хэдэйдсэн ер бусын илрэл гарал бүхий онцгой байр суурь, тусгай эрх мэдэлтэй хүнд хэрэглэгдэнэ. Түүнтэй адилавар хэрэглэгдэх үгсэд бас хувилгаан, гэгээн, шатран гэж гарна. Шашин номын ухаанд гарах «хутагт» гэдэг үгийн хамгийн энгийн тайлбар нь хувилгаан – өмнөх төрлийн онцгой лам хуврагийн насан хутаг төгс, нирван дүр үзүүлсэн хойно түүний бие төрх, сүг сүнс хойдох хэд хэдэн хүний бие дээр амилал олж дахин төрж тодорсоноор тайлбарлагдана.

Бурхан шашны номлолд энэхүү шашныг үүсгэн байгуулагч Шагжамуныг бодит хүн байснаар өгүүлэхээс гадна түүнийг бас номын бие, төгс жаргалангийн бие хийгээд хувилгаан биетэй гэж өгүүлдэг билээ. «Мэргэд гарахын орон»-д тэмдэглэснээр «номын хаан бурхан ялж төгс өнцсөн цогт ялгасан Шагжамуни хэмээн яруу алдараар гурван ертөнц дагина тийн бөгөөд дүүргэсэн мөн тэр бэр. Ямагт ба бүрний тулд дээдээр сэтгэлийг үүсгэн. Гурван асанги галавд үйлдэхүй бэрх ахуй их буян ба билэг билгийн чуулганыг хорьж зузаан зохиолд аганистагийн оронд дээргүй билэг билгийн аршаа-

ны манлай хутагийг олоод төгс жаргалангийн биеийг илт болгоно. Мөнхүү тэр гашана зуун хөлтэй тоотон ертөнцийн оронд хувилгаан биеийн тийн цэнгэлд дөшдийн орноос зүүтгэх түргүүтэн олон зүйл арван хоёр зохиолыг хамт нэгэн үзүүлэн зохиосон...» гэж Шагжамунийн хувьд, төгс жаргалангийн бие хийгээд хувилгаан биеийн нэрийдэл хэмээн гарна. Төгс жаргалангийн бие гэдэг нь Шагжамунийн төрлийн үеийг өгүүлсэн бурхан шашны номлолд түүний өмнөх төрлийг бодисадва байснаас хувилан төрсөн гэх буюу тэр нь ямар нэгэн хүн амьтанд хувилж байсныгаа ер бусын дэмбэрэл, хувь тавилангаас бурхан биеэр тодрох мэтчилэн яригдана. Тэрчлэн бурхан Шагжамунийн биеийг «мөн чанарын бие, билэг билгийн номын бие, махбодийн бие», «номын бие, эдлэх бие, хувилгаан бие» гэж гурван янз буюу «хувилгаан бие, хувилгаан бие, мөн чанарын бие, бэлэг билгийн номын бие» гэж дөрвөн янзаар нэрлэх тохиолдол зөндөө харагдана. Тиймдээ Шагжамунийн махбодийн бие нь хэдийгээр таалал төгсч нирван дүр үзүүлсэн атал түүнээр харин мөн чанарын дүр буюу хувилгаан дүрээр илрэн шүтээнүүддээ үргэлжлэн их хүлгэний ном сургаал хайрласнаар өгүүлэгддэг учиртай. Дээрх өгүүлэлээс ажихад «хувилгаан» гэдэг үгэнд нэг биеийн амь нөгөө нэгэн биед ер бусийн хэлбэрээр шилжин, хувилан төрж болох гэсэн санаа харин аль эртнээс нуугдаж байсан ажээ.

Төвдийн шашинд «хутагт» гэдэг монгол үг хэрэглэгдэхээс өмнө, монгол үгийн «хувилгаан» гэдэгтэй утга нэгтэй «бүрилва» буюу «бүрилва бие» гэдэг үг нэлээд эртнээс хэрэглэгдэж байсан юм. Тэрхүү тусгай нэрийдэл нь бурхан багш, бодисадва нарт нийгэм чанартай зориулагдан хэрэглэгдэж байснаасаа арай нарийсан төвдийн шашны зүтгэлтэнд онц зорилттой хэрэглэгдэх болсон нь түвдийн шашны хожуу дэлгэрэлтийн үед тохиолдоно. Түүний тухай төвдийн Ринбүчий Дунгар Лувсанпэрэнлэйгээр «шашны урсгалын тухай өгүүлэл» хэмээх туурвилдаа тодорхой тэмдэглэжээ. Түүний өгүүлэхээр Төвдэд ламын дахин төрөл олсныг тодлох ёс нь XIII-дугаар зууны сүүлчээр буй болжээ, Суранзанганвугийн үеэс анх дэлгэрэлтэй төвдийн бурхан шашинд ерээс тийм ёс нь тавдугаар равжуны гал гахай жил болтол байгаагүй. Тэр үе Энэтхэгээс Төвдэд ирж шашин дэлгэрүүлсэн их багш Бадамжуннай, их хамба Бодхисхва, Жуу Адиша болон Төвд оронд цолгорсон Юдуг Ёндонжамц, Ринчинсамбуу, Марба, Миларигба гэх нэрт хүмүүст дараа төрлийг нь тодолсон явдал ер байгаагүй. Харин «төвдийн тавдугаар равжуны усан хонин жил Гармаа багш (Гармаба цагаан малгайт хоёрдугаар дүр, багш гэх монгол үг, лам гэсэн утгатай) бие эцэслэж түүний дараа жил модон мичин жил Гарамба Ренчиндорж (Гармаба хар малгайтны гудгаар дүр) мэндлээд таван нас хүрэх шороо хулгана жилд нь, Гармаба багшийн шавь бөтөөлч Узайнба Ринчинбалаар Гармаба Рин-

чиндоржийг сая Гармаа багшийн дахин тодорсон дүрээр тодлон таниад Цүрб хийдэд ширээн залсан нь Төвдэд гарсан ламын дараа төрлийг тодлон тогтоохын анхдагч ажиллагаа болсон бөгөөд түүнээс хойш төвдийн бусад шашны бүлгүүдэд бас тэр ёс дараалан тархсан байна» гэжээ. Өөр нэгэн төвд эрдэмтэн Шинса Галсанцойжжалцаны туурвисан «төвд монгол шашны гарлаг»-д, төвдийн шашинд Гажидбагийн бүлэгт нь дотроо нь бас дөрвөн том найман жижиг салбарлал бий. Түүний доторхи Гармаа гажид болбол хослошгүй Дагва Ринбүчийгийн шавь Гармадуйсумкайнбаас эхлэн алдаршсан юм. Түүний үйлсийг олон шавь нарынхан дотроос Бумцагбагийн шавь байсан Гармаа багш хэмээн залгамжилжээ. «Хоёрдахь дүрийн Гармаа багш доод Амдогийн Лайзагт гэдэг газар төржээ. Дараань Вэй оронд Бумчагба тэргүүтэн олон мэргэдээс уншлага хичээл хийгээд уддисын зүйлсийг олонт сонсож, бясалгал үйлдсэнээр илт ухаарсан байжээ.

Тэрээр Цүрб хийдэд сууж байхдаа арван зургаан бодь номлол зохиожээ. Хятад Монгол оронд очоод олон бүхний алдар гайхамшигт рид шидийг гурвантаа үзүүлсэн бөгөөд тангууд Кахьгийн оронд сүм хийд, шашны сургууль байгуулсан байна. Тэрээр Мөнх хааны Диширээр хүндлэгдэж Гармаа багшийн цол хүртжээ. Жинхэнэ алдар нь Чойжи лам гэдэг байсан юм. Алтан эмжээртэй, ажлын хар малгай хүргэгдсэн болохоор хар малгайт Гармаа гэж алдаршижээ. Хожим Монголоос Вэй орондоо нь очоод таалал болох үед өөрийн багш Луусын Бүтээлч Ужайбад, Ладойдын орноос минь залгамж хувилгаан бие тодрох тул минь хийсэн зөгнөлөөр түүнийг ширээнд суулган тэдгэмжилж, ялгасны орныг эзлүүл хэмээн захиад өнгөрчээ.

Хожим нь Ладойд орноос ирсэн нэгэн бяцхан билэг сайтай хөвгүүн тэрээр, өөрийгөө Гармаба мөн хэмээн тодлон ярьсан бөгөөд итгэлтэй үгсийг олон гарган өгүүлсэн болохоор Гармаа багшийн хувилгаанаар тодлогджээ. Тэгээд гуравдугаар дүрээр ширээнд залагдаж нэрийг нь Ренчиндорж хэмээн айлдав. Энэ бол Төвд оронд хувилгаан бие гарсны түрүүн юм» гэж байв. Дээр ишилсэн хоёр хэллэгийг ерөнхий өгүүлвэл: Төвдэд гарсан шашны бүлэгтэнээс Гажидбагийн бүлэгийг алдаршуулсан Гармадуйсумкайнбагийн шавь Чойж хэмээгч лам Монгол оронд очоод ном тавьж, Мөнх хааны хүндлэлийг олж Гармаа багш хэмээн цоллогдож, алтан эмжээртэй хар малгайгаар шагнагдсан байна. Түүнийг таалал болсон хойно номын үйлсийг нь залгамжилсан Ренчиндоржийг дараа төрөл нь хэмээн тодолсоноос эхэлж, хувилгаан тодлох үзэгдэл гарч, залгаагаар бусад бүлэгтэнд ч хэрэглэгдэх болсон байна. Хамгийн анхны хувилгааныг тодолход төрийн тэргүүн буюу шашны тэргүүн бус, өмнө дүрийн хүнтэй багш шавийн барилдлагатай хүний дурдлага, эсхүл өмнө дүрийн хүн өөрийн залгамжийн тухай болсон бэлэг зөгнөл чухал үйлдэл гаргадаг байсан нь ажиглагдана. Төвд шашны түүхэнд

хүмүүс Гармадуйсумкайнба жич шавь Чойж ламыг Гармабагийн эхний хоёр дүрээр нэрлэн заншиж, гуравдугаар дүр Ренчиндоржоос хойдох Гармабагийн хувилгааныг дөрөвдүгээр дүр Рулбайдорж, тавдугаар дүр Дайшинсайгба, зургаадугаар дүр Дунвадундан, долдугаар дүр Чойрагжамц, наймдугаар дүр Мижиддорж, есдүгээр дүр Ванчигдорж, аравдугаар дүр Чойндорж, арван нэгдүгээр дүр Ишдорж, арван хоёрдугаар дүр Чанчувдорж, арван гуравдугаар дүр Тойдолдорж, арван дөрөвдүгээр дүр Дайгчогдорж, арван тавдугаар дүр Кэкэвдорж, арван зургаадугаар дүр Ринчунригвайдорж, арван долоодугаар дүр Үжинпэрэнлэйчог гэж алдаршуулан нэрлэдэг юм. Гармаа гажид дотроо хар, улаан малгайт гэж хоёр хуваагдана. Улаан малгайт нь түүхэндээ арван дүр уламжлагджээ.

Монгол оронд бурхан шашин дэлгэрэхээс өмнө «хутагт» гэдэг үг монгол сурвалжид хэрэглэгдэж байсан нь «Монголын нууц товчоо», «Хуа и и ю бичиг»-т Нанду хутаг, Өлзий хутаг, Өлзийт хутагт гэхчилэн гарна. Харин түүнийг шашны өнгө будаг хадагдаж эхлэсэн нь Хубилай хааны үетэй холбогдож байна. Нэгэн төвд ном «Төвд монгол шашны гарлага»-д тэмдэглэснээр «Хаанаар гучин зургаатай Пагбагаас дахин авшиг авхуйдаа Минагийн Залгууд хэмээгчээр хааны хэрэглэдэг шилэн лонх үйлдүүлж, огторгуйн доор, газрын дээр, жагар тэнгэр хөвгүүн, хувилсан бурхан, үсэг зохиогч, улсын хилийг түвшитгэсэн хүний орон дахь таван ухааны бандид Пагба Дишири хэмээн цол соёрхов. Хожим хутагт хэмээн цол өгсөн нь ч тэр үед түгэн тархсан юм» гэжээ. Мөн тэмдэглэлд Хубилай хаан Пагбагаас ном сонсож авшиг аваад харихад нь цол миндаг хайрлахдаа түүнийг Энэтхэгээс үүсэлтэй бурхан шашин хийгээд бурхан шашныг үүсгэгч хүнтэй бодож хувилгаан Бүрилва гэж үзсэн бөгөөд Пагба хэмээх төвд үгийн алдар цолуудаас хутагт, богд гэсэн утга байгааг харгалзсан нь илэрхий байна. «Хутагт» гэдэг үгийг Пагба ламд эхлэж хэрэглэснээс шашны өнгөтэй болсоныг гэрчлэх хажуугийн нэгэн жишээ нь «Алтан хааны тууж»-д «Хубилай сэцэн хаан хэмээн алдаршсан богд, хутагт Пагсба ламыг залж ирүүлээд, хотол судар тарни тэргүүтнийг уйгар аялгаар орчуулаад» гэж тэмдэглэснээс мэдэгдэнэ. Хэрэв тэр үед «хутагт» гэдэг үг төдий л идэвхтэй хэрэглэгдэхгүй байсан ба хэрэглэгдэхдээ голдуу хутаг билэг, өлзий хутаг хэмээн оюун ухаан, суу билэгтэнийг тодотгож байсан нь хожмын үе ялангуяа шашны сурвалжид хүндэт ихэс ламын байр суурь жич тэдний дахин амиласныг анхааралдаа авч үзэхгүй бол болохгүй буюу.

Бурхан шашин Монгол оронд анх эхлэн орж ирэх үе бурхан бодисадва, ном судар, сахил санваар, өргөл тахилгын үйл ажилагааг биечлэн сурталчилж, хүчлэн ухаарч байгааг лам, багш, улсын багш, хааны багш гэхчилэн хүндэтгэн дээдэлж, өргөмжлөн шүтэж байсан боловч тэр үед тэдгээр хүмүүсийг насан эцэслэж таалал төгсөхөд дараа

төрөл нь хэзээ, хаана, хэнд яаж тодрон мэндэлээд өмнөх хүнийхэн үйлийг хэрхэн залгамжилан гэдэг санаа оноо нийгэм нийтэд үүсэл байжээ. Тэгэхлээр тийм ухааныг илэрхийлсэн «хувилгаан», «хутагт», «бүрэлва» гэдэг үгс ч төдий л хэрэглэгдээгүй байсан нь учир тодорхой. Харин монголын Түмэдийн Алтан хаан, төвдийн Гэлүгбагийн нэрт лам, урьд хожид Брайбун хийдийн Камбо, Сайра хийдийн эзэн болсон Содномжамцыг тусгайлан урин залж, бие биеэр уулзан, бурхан шашныг номлон хүндэтгэн тахиж, «хамгийг мэдэгч Очир Далай лам» хэмээн эрхэмлэн цолсноос хойш, төвд монголын шашинд «Далай лам» гэдэг тусгай нэрийдэл тогтож, Содномжамцыг нас эцэслэсний дараа төвдийн Брайбун хийдийн ихэс лам нар түүний хувилгаан төрлийг Алтан хааны хойноос магадлан тодолож алдаршуулсан нь дараа Ёндонжамц билээ. Хожимын хүн Содномжамцаас өмнө хоёр дүр - Зонховын шавь, Гэлүгбагийн нэрт хамба Гэндэнжув, Гэндэнжамц нарыг нэг хоёрдугаар дүрийн далай лам гэж нэхэмжилэн өргөмжлөө Содномжамцыг гуравдугаар, Ёндонжамцыг дөрөвдүгээр гэхчилэн уламжлан алдаршуулсанаас эдүгээ хүртэл далай ламын хувилгаан төрөл тасалдалгүй арван дөрөвдүгээр үедээ үргэлжилж байна. Төвд уламжилалт бурхан шашинд шашин төрийн нэгдэл эрх эзэгнэсэн далай ламын хувилгаанаас гадна Банчин эрдэнийн хувилгаан гэх бас нэгэн том хутагтын систем буй. Тэднийг нэгбүрчилэн тодлон тогтооход бас янз бүрийн түүхэн өнгөрөлтийг дамжсан байжээ. Харин тэднээс өөр бусад системийн хутагт хувилгаад, онцгойлон монгол орны сүм хийдэд бий бологсод хэрхэн үе дараалдаг байсныг тус өгүүлэл анхааралдаа авна.

Монгол орны хутагт хувилгаадын төрөл үеийн тодлолт

Одоо бид Монгол оронд шашин ном дэлгэрхийг дагалдан олон тоогоор буй болсон хутагт хувилгаадыг чухам хэн хүн, хэрхэн тодлон тогтоож,

амилуулан биелүүлж байсныг доорхи хэдэн зураадасаар тоймлон өгүүлэе.

Нэг. Далай ламын өргөмжлөсөн хутагт хувилгаад.

Хоёр. Банчин эрдэний өргөмжлөсөн хутагт хувилгаад.

Гурав. Манж Чин хаадын өргөмжлөсөн хутагт хувилгаад.

Дөрөв. Төвдийн шашны эхсээс өргөмжлөсөн хутагт хувилгаад.

Тав. Монгол Хамаг орны өргөмжлөсөн хутагт хувилгаад.

Зургаа. Төр шашин хамтдаа өргөмжлөсөн хутагт хувилгаад.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Алтан хааны тууж. Үндэстний хэвлэлийн хороо, 1984 он, 264, 188, 123-р нүүр.

2. Галдан туслагчийн 1841 онд зохиосон «Эрдэний эрх». Улаанбаатарын хэвлэл, 1959 он, 91-р нүүр.

3. Мэргэд гарахын орон. Үндэстний хэвлэлийн хороо, 1988 он, 17-р нүүр.

4. Сэлхжав, Лха. Оюунбилиг. Баткар сүм. Өвөр монголын шинжлэх ухаан цэнгэг мэргэжлийн хэвлэлийн хороо, 1991 он, 61-79-р нүүр.

5. Төвд эрдэмтэн Шинса Галсанчойжижалзаны туурвисан «Төвд монгол шашны гарлаг» (төвд хэл дээр). Үндэстний хэвлэлийн хороо, 1992 он, 566, 656-р нүүр.

6. Төвдийн Ринбүчий Дунгар Лувсанпэрэнлэй «Шашны урсгалын тухай өгүүлэл» (төвд хэл дээр). Үндэстний хэвлэлийн хороо, 2004 он, 82-р нүүр.

7. Үзэгдсэн бүхний хураангуй (төвд хэл дээр). Үндэстний хэвлэлийн хороо. 1988 он, 295-р нүүр.

8. Хөххотын сүм хийд. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1982 он, 98-р нүүр.

9. Цагаан лянхуа эрхэс. Үндэстний хэвлэлийн хороо, 1996 он, 208-р нүүр.

10. Эрдэний товчоо. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. - 1981 он, 445, 460, 501-р нүүр.

11. 妙丹: «蒙藏佛教史», 京城印局, 1935年, 下册, 五 第39, 10, 32

ББК 86,35 (2 Рос=Калм)

О СТУПАХ ШКОЛЫ КАГЬЮ, ПОСТРОЕННЫХ В КАЛМЫКИИ

А.Г. Кукеев, Б.А. Шантаев

Статья подготовлена при поддержке РГНФ, проект № 09-01-36700е/Ю

В статье рассматривается история возведения мастерами школы Карма-Кагью буддийских ритуальных сооружений «ступа» на территории Республики Калмыкия.

Ключевые слова: *ступа, реликвии, Кагью.*

The article is devoted to the history of creation of the Buddhist ritual monuments “stupa” by Karma-Kagyuu masters in the Republic of Kalmykia.

Keywords: *stupa, relics, Kagyu.*

За последнее десятилетие в Калмыкии построено более 20 буддийских храмов хурулов.

Повсеместно в районах, в больших и малых населенных пунктах возводятся ритуальные